

Л.Мөнхтуяа, МУБИС-ийн МБУС-ийн Математик, Байгалийн ухааны сургалт арга зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D)
Б.Бадамсүрэн, МУБИС-ийн МБУС-ийн Мэдээлэл зүйн тэнхимийн багш, магистр
Ц.Гэрэлтуяа, МУБИС-ийн МБУС-ийн Мэдээлэл зүйн тэнхимийн багш, магистр

МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙ, ҮР ДҮН

Abstract: It is the teachers, who have the responsibilities to change the pupils by providing great education, and molding the kids to become great human beings. In order to fulfill their responsibilities, they should have good knowledge, keep self updated on latest development in the field of education. To take on the responsibility, they should have great foresight to the future. In accordance with the ICT development, there is a change to a student needs and interests. There is an urgent demand not only to educate the children but also to develop herself continuously, to strengthen the position in a society, to have a quality teaching and improve teaching skills in the fact that, the education reform directly depends on the role of the quality teaching. The presentation highlights one of the ways to develop teacher education.

Key words: ICT development, students' needs and interests, development of teacher education

1. Багшийн хөгжлийн талаар

Багш суралцагчдаа судлах, хөгжүүлэх, сурган хүмүүжүүлэхэд өөрийн мэдлэг, ур чадвар, хандлагаа сайжруулах, тасралтгүй хөгжих шаардлагатай байдаг билээ.

Багшийн хөгжил гэдгийг багш мэдлэг, арга барил, ур чадвар, харилцаа, хандлагаа цаг үетэйгээ нийцүүлэх, өөрчлөх бүтээлч үйл явц гэж авч үзсэн байна[1].

Багшийн хөгжлийг багшийн мэдлэг чадварт гарах чанарын өөрчлөлт ч гэж үзэж болно.



Багшийн хөгжилд багш бие хүн өөрөө голлох үүрэгтэй байдаг. Багш өөрийн сурган хүмүүжүүлэх ажилдаа үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх явдал нь багшийн хөгжлийн үндэс болдог.

Багшийн тасралтгүй сурч хөгжих үйл явцын үр дүнд боловсролын салбарт шинэ мэдлэг, хандлага, итгэл үнэмшил, соёлын үнэт зүйлс бий болж байдаг. Багшийг хөгжлийнх нь хүрээгээр:

- Хөгжих бололцоотой;
- Хөгжиж буй;
- Хөгжсөн багш гэж ангилдаг байна.

Багшийн хөгжил нь төр нийгмийн зүгээс багш нарыг хөгжүүлэх, нөгөө талаас багшийн өөрийгөө хөгжүүлэх гэсэн хоорондоо уялдаа хамаарал бүхий үйл явц юм.

2. Багш яагаад хөгжих гэж

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл явц нь мэргэжлийн болон сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн мэдлэг, арга барил, ур чадвар, үзэл бодол, харилцаа, хандлага, сэтгэлгээгээ бие дааж, өөрчлөн сайжруулахад чиглэдэг.

Багшийн хөгжилд дараах хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд:

- Цаг үеэ мэдэрч, ирээдүйгээ баримжаалан сэтгэх чадварын төлөвшил;
- Хамт олны үйл ажиллагааны бүтээлч уур амьсгал;
- Эцэг эх, сурагчдын хэрэгцээ, сонирхлыг мэдрэх чадвар;

- Өөрийн ажил мэргэжлийн үр чадварын төлөвшил, ажилдаа хандах дур сонирхолтой байгаа зэрэг болно.

Багшийн хөгжил нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа бүтээлчээр хандахаас эхэлдэг.

Бүтээлчээр хандах гэдэгт өөрийн нөөц боломжийг ашиглах, өөрийн арга ухаанаар ажиллах, сурагчдаа идэвхжүүлэн урамшуулж ажиллах, өөрийн арга барилтай болохын тулд ажиллахыг хэлнэ.

Багшийн хөгжилд экологийн, үйл ажиллагааны, судалгааны, хөтөлбөрийн насан туршдаа суралцахуй, нийгэм соёлын, сэтгэл хөдлөлийн, харилцааны, МХТ-ийн чадамжуудыг багтаан авч үздэг.

Сургалтын технологид гарч байгаа шинэчлэлийг цаг тухайд нь ойлгон мэдэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багшийн хөгжлийн тулгуур болно.

3. Багшийн хөгжлийг дэмжих сургалтын төрөл

Өнөөдөр багшийн хөгжлийн талаар төрөөс баримталж буй бодлогын хүрээнд багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр БМДИ-ээс 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын үндсэн сургалтыг зохион байгуулж байна.

Мөн төрийн болон хувийн их, дээд сургууль, төрийн бус байгууллагууд БШУЯ-аас баталсан тусгай хөтөлбөрөөр сургалт явуулж байна. Тухайлбал:

1. Багшлах эрхийн сургалт
2. Кредиттэй төрөлжсөн сургалт /40ц/
3. Сертификатын сургалт
4. Багш өөрөө бие дааж суралцах, өөрийгөө хөгжүүлэх ажил

4. Практик тал

Багшийн хөгжлийг дэмжих сургалт, үр дүн

Боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг хүргэх, боловсрол судлал, мэргэжлийн дидактик болон мэдээлэл зүйн шинэчилсэн хөтөлбөрийн агуулга, арга зүй, багшлах үр чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготойгоор 2013 онд Улаанбаатар хот болон Ховд аймагт бүсчилсэн байдлаар зохион байгуулагдсан сургалтад 21 аймаг, 9 дүүргийн 5 дахь жилдээ ажиллаж буй мэдээлэл зүйн 54 багш хамрагдсан. Бидний зохион байгуулсан сургалтын үр дүнд багш хэрхэн суралцаж, цаашид яаж хөгжих чиг хандлагыг олж авахыг илрүүлэх зорилгоор судалгаа авлаа.

Багш нарын судалгааг асуулт бүрээр харьцуулж авч үзвэл:

1. Боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх мэдээлэл, мэдлэг авдаг уу?


Боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх мэдээлэл, мэдлэг авдаг уу?



Энэ диаграммаас харахад, багш нар боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх мэдлэг, мэдээлэл маш сайтай байна.

2. Сургалтын хөтөлбөр боловсруулах мэдлэг, чадвар тань ямар байдаг вэ?


Сургалтын хөтөлбөр боловсруулах чадвар таньд ямар байдаг вэ?



Судалгаанаас үзэхэд, багш нарын сургалтын хөтөлбөр боловсруулах мэдлэг, чадвар сайн байна.

3. Сургалт хүүхэд нэг бүрийг сургах, мэдлэг бүтээлгэх, чадварыг хөгжүүлэхэд тус дэм болох арга, технологи олж авахад дэмжлэг болсон уу?

Сургалт хүүхэд нэг бүрийг сургах, мэдлэг бүтээлгэх, чадварыг хөгжүүлэхэд тус дэм болох арга, технологи олж авахад дэмжлэг болсон уу?



Эндээс үзэхэд, багш нар сургалтаас хүүхэд бүрийг хөгжүүлэх, мэдлэг бүтээлгэх, чадварыг хөгжүүлэх арга технологи нь өсөн нэмэгдсэн



байна.

4. Цаашид өөрийгөө хөгжүүлэхэд хэрэгцээтэй, мэдлэг, арга технологи


Цаашид өөрийгөө хөгжүүлэхэд хэрэгцээтэй, мэдлэг, арга технологи



Энэ сургалтаас багш нар өөрийгөө хөгжүүлэх, багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхүйц хэрэгцээтэй мэдлэг, арга зүй, программ хангамжийн талаар суралцсан байна.

5. Анги удирдах, эцэг эхтэй ажиллах арга зүйтэй болсон уу?

Анги удирдах, эцэг эхтэй ажиллах зохих хэмжээний арга зүйтэй болсон уу?



Эндээс харахад, сургалтад мэдээлэл зүйн багш нарт анги удирдах, эцэг эхтэй ажиллах арга зүй дутмаг оруулсан байгаа нь харагдаж байна.

Багш нар сургалтад хамрагдсанаар:

- МХТ-ийг боловсролд хэрэглэх;
- Сургалтын шинэ программыг судалсан;
- Боловсролын шинэчлэлийг өөрийн үйл ажиллагаандаа тусгах, хэрэгжүүлэх мэдээлэлтэй болсон;
- Сургалтын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, арга зүй, уялдаа холбоог ойлгох;
- Хичээлийн судалгаа хийх шинэ арга зүйд суралцсан;
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүйн талаар судалсан;
- Суралцагчаа судлах арга барил эзэмшсэн;
- Мэргэжлийн ур чадварын хувьд өсөн нэмэгдсэн;
- Хамтран ажиллаж бие биеэсээ суралцах боломж бүрдсэн;
- Хувь хүний нийгэмших чадвар хөгждөг гэсэн

байна.

Багш ажлын байрандаа хөгжихөд сургуулийн МХТ-ийн дэд бүтэц, орчныг сайжруулах нь ихээхэн нөлөөтэй гэдэг нь харагдаж байна.

Багш нар сургалтад хамрагдсанаар цаашдын багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ямар шинэ санааг нэгтгэн авч үзвэл:

- Сургалтын программыг сургалтын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх;
- Хичээл заах арга зүйд суралцах;
- Боловсролын нээлттэй багцыг ашиглах;
- Багаар хамтран ажиллаж хичээлийн судалгаа хийх;
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх;
- Судалгааны арга барилд суралцах;
- Суралцагчийг үнэлэх арга зам, хэлбэрийг судлах;
- Онолын болон практик мэдлэг, чадвараа дээшлүүлэх;

Багш ажлын байрандаа хөгжихөд бэрхшээлтэй байгаа зүйлийг тодруулахад:

Багшлах арга зүйтэй:

- Хичээл заах ачаалал их;
- Хичээлийн бэлтгэл их хийдэг;
- Судлах ном, гарын авлага дутмаг Сургалтын орчинтой холбоотой:
- Орчин байхгүй;
- Компьютер, интернэт, дэд бүтэц дутагдалтай;
- Зарим хүндрэлтэй сэдвүүдийн онол дутмаг байна.

Эндээс үзэхэд, багш нар ажлын байрандаа хөгжихөд тодорхой бэрхшээлүүд байдаг байна.

САНАЛ

Тусгай хөтөлбөрөөр тодорхой хугацаанд, бүлгээр суралцах нь үр дүнтэй байдаг гэсэн санал багш нараас их гарч байлаа. Цаашид дараах зүйлийг судалмаар байна. Үүнд:

- Боловсролын шинэчлэлтэй танилцаж, сурган хүмүүжүүлэх үйлд ашиглах;
- Шинэ тутам гарч буй сургалтын программ хангамжийг судлах;
- Вэбэд суурилсан сургалтыг модулиар зохион байгуулах;
- Мэдээлэл зүйн шинэ арга зүйтэй холбоотой материал судлах.

ДҮГНЭЛТ

Багш нар тусгай хөтөлбөрөөр суралцсанаар багш нарын хөгжилд боловсролын шинэчлэл, сургалтын шинэ арга зүй, сургалтын программыг багшлах үйл ажиллагаанд ашиглах үйлд дэмжлэг үзүүлсэн байна.

Гэхдээ сургалтыг зохион байгуулаад

зогсох биш багшийн хөгжилд ямар дэмжлэг үзүүлж байгаа үр дүнг харахын тулд онлайн сургалтаар цааш үргэлжлүүлэн 1-3 сараар суралцах боломжийг олгож хамтын хэлэлцүүлэг өрнүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ичинхорлоо, Ш. (2012). *Багшийн ном*.
Улаанбаатар

Пүрэвдорж, Ч. (2012). *Багшлахуйн менежмент*,
Улаанбаатар

Эрдэнэцэцэг, С., ба бус. (2010). *Багш боловсролын үндэс*. Улаанбаатар

www.meds.gov.mn

http://csms.edu.mn/result/download1/articlecollection/b_gerelchimeg_1346915032.pdf

<http://educationalaspirations.com/2013/06/17/risk/>